



ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДАРХАН-УУЛ АЙМАГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр Дархан-Уул аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, чадавх, үр нөлөөг үнэлэх мониторинг хийлээ. Иргэний зөвлөл нь Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийг төлөөлөн хяналт тавих үүрэг бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны бус иргэний төлөөлөл байх бөгөөд аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэд үйл ажиллагаагаа явуулдаг.

Мониторингийн гол үр дүнг доор товчлон харуулсан бөгөөд дэлгэрэнгүй тайланг бүрэн эхээр нь www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН ДҮН

ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТУХАЙД

- 2014-2017 онд Дархан-Уул аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь анх 5 гишүүнтэй байгуулагдсан. Тэдний 3 буюу 60 хувь нь зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан хүмүүс байсан бол 2017 онд бүрэлдэхүүн шинэчлэгдсэний дараа энэ салбарт ажиллаж байсан хүмүүс нийт гишүүдийн 40 хувийг бүрдүүлж байна. Хуучин болон шинэ бүрэлдэхүүнд зөвхөн 1 эмэгтэй сонгогдон ажиллаж байгаа бөгөөд 43-64 насны хүмүүсээс бүрдэж байна.
- Иргэний зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулахдаа “цахимаар болон сум багийн хурлаар санал авах” журамтай. Гэтэл цахимаар санал авах үед салбарын тухай ойлголт багатай, Иргэний зөвлөлийн тухай мэдлэггүй ч цахим сүлжээнд идэвхтэй байгаа залуучууд голдуу саналаа өгч байгаагаас зохих туршлагатай хүмүүс сонгох боломжийг хязгаарлаж байна. Харин сум, багийн хурлаар танил талаараа сонгогдох боломж өндөр байна.
- Иргэний зөвлөл нь ажил үүргээ гүйцэтгэх албан өрөөгүй тул Засаг даргын иргэдтэй уулзах танхим, эсвэл гишүүн байгууллагын ажлын өрөөнд хуралддаг ажээ. Харин Иргэний зөвлөл нь албан бланк, тэмдэгтэй.

ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛЬ, ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙД

- Иргэний зөвлөлийн тайлан, зөвлөмжийг судалж үзэхэд цагдаагийн байгууллагаас ирүүлсэн тайланг давтан сайшаасан шинжтэй, нөхцөл байдалд тодруулга, судалгаа хийгээгүй, хэрэг зөрчлийн статистик мэдээллийг хуулбарлаж, цөөн асуудлаар зөвлөмж, санал гаргасан шинжтэй байв.

- Иргэний зөвлөл ажиллах хугацаандаа аймгийн Засаг дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандан “автопаркийн шинэчлэл хийх; төрийн үйлчилгээний нэгдсэн системд ээлжийн 3 ажилтны орон тоог бий болгох; олон нийтийн цагдаагийн алба байгуулах ажлыг түргэсгэх; морин эргүүл, иргэд аж ахуйн нэгжийн эргүүлийг гэмт хэрэг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах; архины албадан эмчилгээний цэг байгуулж, орон тоог шийдэх; гэр бүл эцэг эхчүүдэд зөвлөгөө өгч, сургалт явуулах бүтцийг бий болгох” санал гаргасан байна. Эдгээр саналаас төрийн үйлчилгээний нэгдсэн системд цагдаагийн алба хаагчид ажлын 8 цагаар ээлжлэн ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд тусгай өрөөнд зөвлөгөө өгөх саналыг ажил хэрэг болгожээ.
- Цагдаагийн газарт хандан гаргасан саналаас өргөдөл, гомдол авах хайрцаг ажиллуулах саналыг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.
- Иргэний зөвлөл нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг иргэдэд таниулах, цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллага хамтран ажиллах асуудлаар тус тус уулзалт, сургалт зохион байгуулжээ.
- Иргэний зөвлөлөөс “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцааны соёл, мэдлэг ур чадвар, ажил үйлчилгээ” сэдэвт судалгааг 171 иргэний дунд явуулж, үр дүнг үндэслэн аймгийн Цагдаагийн газарт зөвлөмж санал хүргүүлжээ.
- Иргэний зөвлөл нь иргэд, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр дорвитой ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Иргэний зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах явц оновчтой биш байгаад талууд шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ, мэргэжлийн холбоод, иргэдийн бүлгүүд нэр дэвшүүлж өрсөлдүүлэх замаар сонгох тухай дүрэмд өөрчлөлт оруулах;
- Иргэний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх зарыг аль болох олон эх сурвалжаар түгээх, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах тухай дүрэмд нэмэлт оруулах;
- Иргэний зөвлөлийн гишүүдийг судалгаа, шинжилгээ хийх, тайлан мэдээлэлд үнэлэлт өгөх ур чадвар олгох сургалтад хамруулах;
- Иргэний зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын ажил дүгнэхэд харгалзаж үздэг байх;
- Нутгийн удирдлагын зүгээс Иргэний зөвлөл үйл ажиллагаа явуулах бололцоог олгох үүднээс албан өрөөгөөр хангах, төсөв хуваарилах;
- Иргэний зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг шийдвэрлэх.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт НДЭХ-ий Дархан-Уул аймаг дахь салбараас Иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн үр дүнг хэвлэн нийтлэв. Энэхүү мониторинг нь НДЭХ-ий Дархан-Уул аймаг дахь салбараас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.